ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Хэнтий аймгийн Хэнтий-Ус ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2023/04/НА-СТА-ОНӨААН**

Цахим хуудас:
www.open.audit.mn

Чингис хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Н.Туяа
Утас: 99799709

Цахим хаяг: www.open.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2023.06.02 № 390

танай ______ -ны № ______ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭНТИЙ-УС
ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Г.БАТГЭРЭЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэнтий-Ус ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол дагуу Хэнтий-Ус ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан дахь 30,045,463.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 492,746.5 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, тооцоо бодож баталгаажуулаагүй, 277,667.5 мянган төгрөгийн өглөг, 10,820.6 мянган төгрөгийн урьдчилгаа, 113,105.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тус тус тооцоо нийлж баталгаажуулаагүй, өглөгийг 35,145.9 мянган төгрөгөөр, авлагыг 19,430.3 мянган төгрөгөөр алдаатай бүртгэсэн, татварын өглөгийн тайлангуудыг санхүүгийн тайлангаас 137,543.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, 41,875.8 мянган төгрөгийн олон жилийн насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, хайрганы орлого 2,052.7 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй, хувь хүмүүсээс суутгасан тооцсон 650.0 мянган төгрөгийн татварыг төсөвт төлөөгүй, харилцах данснаас төлбөрийн цахим баримтгүйгээр 623,901.4 мянган төгрөгийн 26 гүйлгээ хийсэн, тендер шалгаруулалтын дагуу гэрээ байгуулж хово машин, чиргүүлийн хамт худалдан авах үнийн урьдчилгаанд 50 хувь болох 124,306.9 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч одоог хүртэл хөрөнгийг хүлээн аваагүй, байгуулсан гэрээнд хөрөнгийг хүлээн авах хугацааг тусгаагүй зэрэг нийт 32,512,076.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Ашигт малтмалын тухай хуулиудын холбогдох заалт, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллагын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

232230494

санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгө 150,975.5 мянган төгрөг, авлага 276,647.2 мянган төгрөг, урьдчилгаа 135,127.5 мянган төгрөг, бараа материал 492,746.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 30,045,463.4 мянган төгрөг, урьдчилж орсон орлого 7,633,883.4 мянган төгрөг, богино хугацаат өр төлбөр 762,493.1 мянган төгрөг, урт хугацаат өр төлбөр 12,184,315.0 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 31,100,960.1 мянган төгрөг байна.

Тайлант онд нийт 7,215,857.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 6,511,438.2 мянган төгрөгийн зардал гарган, 704,419.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Үүнд татаас санхүүжилтээр 866,110.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, мөн урт хугацаат зээлийн өрийг аймгийн ТЕЗ-аас барагдуулсан 799,562.5 мянган төгрөгөөр орлого нэмэгдсэн байна. Борлуулалтын орлогод 5,118,159.6 мянган төгрөгийн, бусад орлогод 432,025.8 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 5,858,137.3 мянган төгрөгийг, үйл ажиллагааны зардалд 653,300.8 мянган төгрөгийг зарцуулжээ.

**Аудитын гол асуудал**

Хэнтий-Ус ХХК нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй боловч голын хайргыг олборлож 227,268.0 мянган төгрөгийн борлуулалт хийсэн нь Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Хэнтий-Ус ХХК-ийн өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад тавих хяналт болон бүртгэл тайлагналтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,047,831,382.47** | **1,055,496,702.66** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **63,366,826.52** | **150,975,518.78** |
| **31100** | **Кассад байгаа бэлэн мөнгө** | **2,235,988.59** | **397,366.28** |
| 31110 | Төгрөг | 2,235,988.59 | 397,366.28 |
| **31200** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **61,130,837.93** | **150,578,152.50** |
| **31210** | **Төгрөг** | **61,130,837.93** | **150,578,152.50** |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 61,130,837.93 | 150,578,152.50 |
| **33** | **АВЛАГА** | **546,569,136.72** | **276,647,165.50** |
| 33401 | Дансны авлага /ТӨҮГ/ | 295,959,602.00 | 191,985,056.30 |
| 33402 | Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/ | 124,280.00 | 42,539,954.02 |
| **33500** | **Бусад авлага** | **250,485,254.72** | **42,122,155.18** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 250,485,254.72 | 42,122,155.18 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **49,566,203.44** | **135,127,499.35** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 49,566,203.44 | 135,127,499.35 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **388,329,215.79** | **492,746,519.03** |
| **35400** | **Хангамжийн материал** | **357,712,634.81** | **462,239,938.05** |
| 35420 | Аж ахуйн материал | 307,710,724.21 | 429,480,695.84 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 50,001,910.60 | 32,759,242.21 |
| 35600 | Мал амьтад | 30,616,580.98 | 30,506,580.98 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **27,265,393,764.32** | **30,045,463,386.87** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **27,265,393,764.32** | **30,045,463,386.87** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **21,907,481,764.32** | **24,687,551,386.87** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 18,862,179,270.77 | 25,365,142,652.07 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,776,333,642.08 | -2,471,437,714.41 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 998,131,957.76 | 1,217,736,957.76 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -588,382,119.04 | -646,591,770.07 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 1,279,649,021.64 | 1,760,994,100.46 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -553,609,092.48 | -632,169,297.84 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 75,704,202.44 | 78,544,202.44 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -70,789,394.23 | -73,680,573.68 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,703,972,881.72 | 197,271,125.09 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -23,041,322.18 | -108,258,294.95 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **5,357,912,000.00** | **5,357,912,000.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,357,912,000.00 | 5,357,912,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **28,313,225,146.79** | **31,100,960,089.53** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **18,497,376,249.31** | **20,580,691,458.52** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **7,879,644,636.85** | **8,396,376,421.54** |
| **41200** | **Богино хугацаат зээлийн өглөг** | **46,833,344.00** | **0** |
| **41210** | **Төгрөг** | **46,833,344.00** | **0** |
| 41214 | Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл | 46,833,344.00 | 0 |
| **41300** | **Өглөг** | **768,178,816.43** | **762,493,045.72** |
| **41360** | **Бусад өглөг** | **768,178,816.43** | **762,493,045.72** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 7,084,574.40 | 0 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 38,380,046.95 | 100,107,776.22 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 127,907,573.51 | 88,681,381.04 |
| 41364 | НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ | 39,870,796.62 | 5,733,732.92 |
| 41366 | Дансны өглөг /ТӨҮГ/ | 554,935,824.95 | 567,970,155.54 |
| **41400** | **Урьдчилж орсон орлого** | **7,064,632,476.42** | **7,633,883,375.82** |
| 41410 | Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 7,064,632,476.42 | 7,633,883,375.82 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **10,617,731,612.46** | **12,184,315,036.98** |
| **42200** | **Урт хугацаат зээл** | **10,617,731,612.46** | **12,184,315,036.98** |
| **42210** | **Төгрөг** | **10,617,731,612.46** | **12,184,315,036.98** |
| 42211 | Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 10,617,731,612.46 | 12,184,315,036.98 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **9,815,848,897.48** | **10,520,268,631.01** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **9,815,848,897.48** | **10,520,268,631.01** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 10,684,688,038.87 | 10,684,688,038.87 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 10,684,688,038.87 | 10,684,688,038.87 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **-868,839,141.39** | **-164,419,407.86** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -745,504,316.62 | -868,839,141.39 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -123,334,824.77 | 704,419,733.53 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **28,313,225,146.79** | **31,100,960,089.53** |

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/ төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **374,494,674.11** | **1,357,720,557.74** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **374,494,674.11** | **1,357,720,557.74** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **374,494,674.11** | **1,357,720,557.74** |
| 120009 | Бусад орлого | 494,643,322.28 | 2,097,698,332.43 |
| 120010 | Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/ | 4,355,398,723.96 | 5,118,159,569.87 |
| 120011 | Борлуулалтын өртөг /ТӨҮГ/ | 4,475,547,372.13 | 5,858,137,344.56 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **497,829,498.88** | **653,300,824.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **497,829,498.88** | **653,300,824.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **497,829,498.88** | **653,300,824.21** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **497,829,498.88** | **653,300,824.21** |
| 210810 | Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/ | 7,456,132.80 | 13,976,234.29 |
| 210811 | Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/ | 371,974,433.55 | 529,051,579.37 |
| 210813 | Бусад зардал /ТӨҮГ/ | 115,770,155.77 | 110,273,010.55 |
| 210814 | Орлогын татварын зардал /ТӨҮГ/ | 2,628,776.76 | 0 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-123,334,824.77** | **704,419,733.53** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-123,334,824.77** | **704,419,733.53** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **1** | **2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **10,684,688,038.87** | **-745,504,316.62** | **9,939,183,722.25** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0** | **0** | **0** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **10,684,688,038.87** | **-745,504,316.62** | **9,939,183,722.25** |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0** | **0** | **0** |
| **5** | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | **0** | **0** | **0** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **6** | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | **0** | **0** | **0** |
| **7** | **Өмчид гарсан өөрчлөлт** | **0** | **0** | **0** |
| **8** | **Зарласан ногдол ашиг** | **0** | **0** | **0** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0** | **-123,334,824.77** | **-123,334,824.77** |
| **10** | **2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **10,684,688,038.87** | **-868,839,141.39** | **9,815,848,897.48** |
| **11** | **2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл** | **10,684,688,038.87** | **-868,839,141.39** | **9,815,848,897.48** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **10,684,688,038.87** | **-868,839,141.39** | **9,815,848,897.48** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | 0 | 0 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 0 | 0 | 0 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0 | 704,419,733.53 | 704,419,733.53 |
| **20** | **2022 оны 12-р сарын 31-аарх үлдэгдэл** | **10,684,688,038.87** | **-164,419,407.86** | **10,520,268,631.01** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,440,234,777.44** | **6,931,386,106.28** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,440,234,777.44** | **6,931,386,106.28** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **5,440,234,777.44** | **6,931,386,106.28** |
| 120009 | Бусад орлого | 184,674,569.25 | 246,258,416.83 |
| 120013 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/ | 4,868,960,208.19 | 5,943,627,689.45 |
| 120017 | Татаас, санхүүжилтийн орлого /ТӨҮГ/ | 386,600,000.00 | 741,500,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,193,643,614.30** | **6,318,827,595.02** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,193,643,614.30** | **6,318,827,595.02** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,193,643,614.30** | **6,318,827,595.02** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,203,884,654.92** | **1,639,105,257.45** |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | 1,203,884,654.92 | 1,639,105,257.45 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **514,786,834.00** | **557,202,325.26** |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 514,786,834.00 | 557,202,325.26 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **532,511,838.74** | **676,655,070.24** |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 532,511,838.74 | 676,655,070.24 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,996,299,427.20** | **2,495,506,493.10** |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/ | 735,847,412.26 | 795,137,251.13 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | 1,260,452,014.94 | 1,700,369,241.97 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **946,160,859.44** | **950,358,448.97** |
| 210815 | Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/ | 12,008,209.10 | 2,312,067.16 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 355,017,167.34 | 476,203,945.29 |
| 210817 | Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 4,624,235.00 | 3,918,438.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/ | 574,511,248.00 | 467,923,998.52 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **246,591,163.14** | **612,558,511.26** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **125,270,800.00** | **478,116,475.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **125,270,800.00** | **478,116,475.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **125,270,800.00** | **478,116,475.00** |
| 225101 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ | 125,270,800.00 | 478,116,475.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-125,270,800.00** | **-478,116,475.00** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **-69,565,895.63** | **-46,833,344.00** |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | **69,565,895.63** | **46,833,344.00** |
| 250002 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө | 69,565,895.63 | 46,833,344.00 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **51,754,467.51** | **87,608,692.26** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 11,612,359.01 | 63,366,826.52 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 63,366,826.52 | 150,975,518.78 |

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл** / мянган төгрөгөөр /

| **Зардлын ангилал** | **Төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү** |
|---|---|---|---|
| Үйл ажиллагааны орлого | 5,116,723.9 | 5,118,159.6 | 1,435.7 |
| Үйл ажиллагааны бус орлого | 666,892.0 | 2,097,698.3 | 1,430,806.3 |
| **Нийт орлогын дүн** | **5,783,615.9** | **7,215,857.9** | **1,432,242.0** |
| Үндсэн үйл ажиллагааны зардал | 5,641,032.7 | 6,511,438.2 | 870,405.5 |
| Үйл ажиллагааны бус зардал | 85,696.8 | | (85,696.8) |
| **Нийт зардлын дүн** | **5,726,729.5** | **6,511,438.2** | **784,708.7** |
| **Ашиг, алдагдал** | **56,886.4** | **704,419.7** | **647,533.3** |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

**Аудитаар нийт 360,099.2 мянган төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:**

1. Санхүүгийн тайланд харилцах дансны үлдэгдлийг 10,000.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулсан.

2. Урьдчилж орсон орлогын тайлант онд ногдох 321,550.0 мянган төгрөгийн орлогыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж хорогдуулаагүй алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулсан.

3. Урт хугацаат зээлийн хүүгийн зардал 24,338.2 мянган төгрөгийг санхүүгийн тайланд бүртгээгүй орхигдуулсан, урт хугацаат зээлийн эргэн төлөлтийг 4,210.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн зэрэг алдаа илэрснийг залруулсан.

**Аудитаар нийт 32,151,977.6 мянган төгрөгийн 15 зөрчил[1] илэрснээс, 2,702.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 31,525,373.5 мянган төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 623,901.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.**

**5.1 Төлбөрийн акт**

1. Харилцах дансанд төвлөрүүлсэн хайрганы орлогыг хайрга борлуулсан бүртгэлтэй тулгахад 2,052.7 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлж, холбогдох тооцоог хийж баталгаажуулаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоов.

2. Хувь хүмүүсээс суутгасан тооцсон 650.0 мянган төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээгүй, бүртгэлд тусгаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

1. Хэнтий -Ус ХХК нь түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй боловч голын хайргыг олборлон, худалдан борлуулах үйл ажиллагааг эрхэлж 2022 онд 227,268.0 мянган төгрөгийн борлуулалт хийж хайрга борлуулсан тайлан, тооцоог гаргаагүй зөрчил илэрсэнд зөрчлийг таслан зогсоох, хууль бусаар олсон орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй 81,316.5 мянган төгрөг, тооцоо нийлсэн акт үйлдсэн боловч тамга тэмдгээр баталгаажуулаагүй 31,788.5 мянган төгрөг, урьдчилгаа дансны үлдэгдэл 10,280.6 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Нью констракшн ХХК-иас авах 4,682.4 мянган төгрөгийн, Умардын од ХХК-иас авах 13,883.3 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын хэлтсээс авах 23,510.4 мянган төгрөгийн барагдаагүй олон жил болсон авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, нягтлан бодох бүртгэлийг алдаатай хөтөлж ажиллагсдаас авах 5,069.1 мянган төгрөгийн цалингийн зөрүүний авлага, нийгмийн даатгалын хэлтсээс авах тайлант онд шинээр үүссэн авлага 2,957.1 мянган төгрөг, хувь хүнээс авах хайрганы тооцооны авлага 11,404.1 мянган төгрөгийн авлага үүсгэсэн зэрэг нийт 185,231.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Санхүүгийн тайланд хувь хүний орлогын албан татварын өглөгийг 9,348.4 мянган төгрөгийн, нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгийг 23,200.0 мянган төгрөгийн алдаатай, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаас 2,597.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, татварын тайлан болон санхүүгийн тайлантай тулгахад нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгийг 102,291.5 төгрөгөөр, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар 16,425.9 мянган төгрөгөөр, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 3424.7 мянган төгрөгөөр, хувь хүний орлогын албан татварын өглөг 3,207.2 мянган төгрөгөөр, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татварын өглөг 100.1 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 5,613.4 мянган төгрөгөөр, ус ашигласны төлбөрийг 6,480.8 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан, байгууллагад төлөх өглөгийн үлдэгдэл 206,691.7 мянган төгрөг, гэрээт хүмүүст төлөх өглөгийг үлдэгдэл 70,975.7 мянган төгрөг, нийт 277,667.5 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, нийт 450,357.0 мянган төгрөгийн зөрчил илэрснийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4. Жилийн эцсийн байдлаар үндсэн хөрөнгийн дансны 30,045,463.3 мянган төгрөгийн үлдэгдэлд тооллого хийгээгүй зөрчил илэрсэнд дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5. Жилийн эцсийн байдлаар бараа материалын 492,746.5 мянган төгрөгийн үлдэгдэлд тооллого хийгээгүй зөрчил илэрсэнд дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**5.3 Зөвлөмж**

1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Мөнгөн зарлагын гүйлгээнд анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсэн эсэхэд түүврийн сорил хэрэгжүүлэхэд 623,901.4 мянган төгрөгийн 26 гүйлгээг төлбөрийн цахим баримтгүйгээр хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын "Маягт заавар батлах тухай" 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. ......" гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Мөнгөн зарлагын гүйлгээг хийхдээ холбогдох хууль, журмын дагуу төлбөрийн цахим баримтыг бүрэн бүрдүүлж байх

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Харилцах дансны үлдэгдэл дутуу | 1 | 10000.0 | 1 | 10000.0 | | | 1 | 10000.0 | | | | |
| УОО-ыг хорогдуулаагүй | 1 | 321550.5 | 1 | 321550.5 | | | 1 | 321550.5 | | | | |
| Урт хугацаат өр төлбөрийн зардал, эргэн төлөлтийг дутуу бүртгэсэн | 2 | 28548.7 | 2 | 28548.7 | | | 2 | 28548.7 | | | | |
| **Дүн** | **4** | **360099.2** | **4** | **360099.2** | | | **4** | **360099.2** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | То о | Албан тушаалтны тоо | То о | Дүн |
| Лицензгүй хайрга олборлож борлуулсан | 1 | 227268.0 | | | 1 | 227268.0 | | | | | | |
| Хайрганы орлого дутуу төвлөрүүлсэн | 1 | 2052.7 | 1 | 2052.7 | | | | | | | | |
| Төлбөрийн цахим баримтгүй | 1 | 623901.4 | | | | | 1 | 623901.4 | | | | |
| Татварыг дутуу төвлөрүүлсэн | 1 | 650.0 | 1 | 650.0 | | | | | | | | |
| Авлагыг алдаатай бүртгэсэн, тооцоо нийлээгүй, барагдуулах арга хэмжээ аваагүй | 4 | 185231.9 | | | 4 | 185231.9 | | | | | | |
| Өглөгийг зөрүүтэй бүртгэсэн, тооцоо нийлээгүй | 4 | 450357.0 | | | 4 | 450357.0 | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй. | 1 | 30045463.3 | | | 1 | 30045463.3 | | | | | | |
| Бараа материалын тооллого хийгээгүй | 1 | 492746.5 | | | 1 | 492746.5 | | | | | | |
| **Дүн** | **14** | **32027670.8** | **2** | **2702.7** | **11** | **31401066.7** | **1** | **623901.4** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тендерийн гэрээнд хугацаа тусгаагүй, хөрөнгийг хүлээн аваагүй | 1 | 124306.9 | | | 1 | 124306.9 | | |
| Дүн | 1 | 124306.9 | | | 1 | 124306.9 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт дүн** | **1** | **124306.9** | | | **1** | **124306.9** | | |